

**"БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК" ОНӨТҮГ
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН ЗАХИРАМЖИЙН
03 ДУГААР САРЫН БИЕЛЭЛТ**

2020 оны 03 дугаар сарын 31

Багануур дүүрэг

№	Ирсэн огноо	Батлагдсан огноо	Дугаар	Биелэлт
1	2019.06.28	2019.06.21	A/619	<p>Паркийн "Үйлдвэрийн албан контор"-ын барилгын зураг төслийг гүйцэтгэгч Нутаг Консалт ХХК-д холбогдох бичиг баримтуудыг гарган, хангагч байгууллагуудаас техникийн нөхцөлийг авч, гадна шугам сүлжээний холболтын цэгийг заалган ажлын зургийг гүйцэтгэсэн бөгөөд Дүүргийн хангагч байгууллагатай зөвшилцсөний дагуу нэмэлт өөрчлөлт оруулсан.</p> <p>Паркийн захиргаа нэгдсэн үйлчилгээний төвийн барилгын ус хангамж, ариутгах татуургын ажлын зургийг "Багануур УС" ААТҮГ-ын удирдлагууд болон гүйцэтгэгч байгууллагатай гурвалсан уулзалт зохион байгуулан зөвшилцөж, техникийн нөхцөлийг дахин шинээр авч, зураг төслийн ажлыг гүйцэтгэхээр шийдвэрлээд байна.</p>
2	2019.10.11	2019.10.09	A/1054	<p>Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн системийг ашиглах журмын хэрэгжилтийг ханган ажилласан. Үүнд: "Багануур үйлдвэрлэл, технологийн парк" ОНӨТҮГ-т 2020 оны 03 дугаар сарын 31-ний байдлаар хариутай 10, хариугүй 10 бичиг нийт 20 албан бичиг ирсэн ба хариутай бичгийн шийдвэрлэлт, хариугүй бичгийн хаалт тус бүр 100 хувьтай байна. "Багануур үйлдвэрлэл, технологийн парк" ОНӨТҮГ-аас ААНБ-уудад нийт 25 хариугүй бичиг явуулсан ба шийдвэрлэлт 100 хувьтай байна.</p>
3	2020.01.28	2020.01.27	A/108	<p>1.6 дугаар заалтын дагуу Албан хаагчдын амны хаалтын хэрэглээг хэвшүүлэн, ажилчдыг Паркийн нэгж болох Монхимо ХХК-ийн бүтээгдэхүүн /санитол/ гар халдваргүйжүүлэх нөхцөлөөр ханган, өглөө бүр ажлын байранд чийгтэй цэвэрлэгээг хийж, хаалганы бариулыг 2 цаг тутамд спиртээр тогтмол ариутгаж байна. Мөн ЭМЯ болон дүүргийн ЭМТ-өөс өгч байгаа зөвлөмж, корона вирусын халдвараас урьдчилан сэргийлэх талаарх мэдээлэл, цаг үеийн мэдээг өглөө бүр албан хаагчдад танилцуулан мэдээллийг baganuur-itr.mn цахим хуудсанд тогтмол байршуулж байна.</p> <p>Захирамжийн биелэлтийг 7 хоног бүрийн пүрэв гаригт Zendmaal@gmail.com цахим хаягт илгээн тайлагнаж байна.</p>
4	2020.02.07	2020.02.07	A/168	<p>1 болон 3 дугаар заалтыг хэрэгжүүлэн, биелэлтийг 14 хоног тутам НЗДТГ-ын ХШ,ҮХ-т тайлагнан ажиллаж байна.</p>
5	2020.02.14	2020.02.13	A/191	<p>Захирамжийн дагуу НОК-ын орлогч даргын баталсан "Шинэ төрлийн коронавирус /COVID-19/-ын өвчлөлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч, иргэдэд зөвлөмж мэдээлэл өгч, эргүүлээр ажиллах хуваарь"-ийн дагуу 2020 оны 02 дугаар сарын 20-ны</p>

				<p>өдрөөс эхлэн Багануур үйлдвэрлэл, технологийн парк нь Багануур дүүргийн Засаг даргын Тамгын газар, дүүргийн Онцгой комисстой хамтран ажиллаж, тус бүрийн баталсан хуваарийн дагуу явган эргүүлийн ажилд хяналт тавьж, дүн мэдээг боловсруулан нэгтгэж, орой бүр 22:00 цагт Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Шуурхай штабт ubhealth2020@gmail.com цахим хаягаар тайлагнан, эргүүлээр ажилласан тоон мэдээг 7 хоногоор нэгтгэж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэст 7 хоног бүрийн баасан гарагт battsoojubcity@gmail.com цахим хаягаар хүргүүлж байна.</p> <p>Мөн уг захирамжтай холбогдон гарсан Монгол Улсад коронавирусын халдварын анхны тохиолдол илэрсэнтэй холбогдуулан УОК-ын 6 дугаар тогтоолын дагуу 0-12 насны хүүхэдтэй эхчүүдийг эргүүл, хяналтаар ажиллуулахгүй байх зохицуулалтыг дотооддоо хийсэн.</p>
6	2020.03.05	2020.02.28	A/268	<p>Нийслэлийн Засаг даргын 02 дугаар сарын 28-ны өдрийн A/268 дугаар захирамж, Нийслэлийн онцгой комиссын 03 дугаар сарын 02-ны өдрийн өргөтгөсөн хуралдааны 07 дугаар тэмдэглэл, Багануур дүүргийн Засаг даргын 03 дугаар сарын 03-ны өдрийн A/76 дугаар захирамжийн хэрэгжилтийг ханган Газрын даргын 03 дугаар сарын 05-ны өдрийн A/16 дугаар тушаалаар холбогдох албан хаагчдын ажлын цагийг 1 цагаар хорогдуулан ажиллуулж байна. Мөн холбогдох албан хаагчдын судалгааг 03 дугаар сарын 06-ны өдрийн 37 дугаартай албан бичгээр Нийслэлийн Статистикийн газарт хүргүүлсэн.</p>
7	2020.03.16	2020.03.11	A/342	<p>Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-ын албан хаагчид 02 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн батлагдсан хуваарийн дагуу, шинэ төрлийн Коронавирус /COVID-19/-ын халдвараас урьдчилан сэргийлж, иргэд олон нийтийг болзошгүй эрсдэлээс сэрэмжлүүлэхтэй холбоотойгоор Багануур дүүргийн хэмжээнд явагдаж буй явган эргүүлийн ажилд хяналт тавин, эргүүлийн нэгдсэн тоон мэдээг өдөр бүр Нийслэл, дүүргийн шуурхай штабд хугацаанд нь тайлагнан маш хариуцлагатай ажиллаж байна. Иймд НЗД-ын A/342 дугаар захирамжийн хэрэгжилтийг ханган байгууллагын албан хаагч нарт 920,000 мян.төг урамшуулал олгосон.</p>

ХЯНАСАН:

“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК”

ОНӨТҮГ-ЫН ДАРГА

Ч.ЭЛБЭГСАЙХАН



БИЕЛЭЛТ ГАРГАСАН:
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Laxwit

Б.НОМИНЗУЛ